

8-Р АНГИЙН МОНГОЛ ХЭЛ ХИЧЭЭЛИЙН АНГИ ДЭВШИХ ШАЛГАЛТЫН ДААЛГАВАР

“ХУВИЛБАР-А”

Анги бүлэг

Сурагчийн нэр

Хугацаа: 60 минут

Нийт – 20 оноо

Эхийг уншиж ойлгоод, даалгаврыг гүйцэтгэнэ үү.

УУРЫН ТЭРЭГНИЙ ГАРАЛ ИЙМ УЧИРТАЙ

Ширээн дээр байгаа данхнаас ямарч дуу аниргүй чимээгүй л байгаа биз. Тэгвэл түүнийг цахилгаан зуухан дээр тавибал хэсэг хугацааны дараа доторх ус нь бужигнаж буцалж байснаа даргилж эхэлмэгц данхны таг тачигнан дуугарч эхэлдэг. Энэ юунаас болж байна вэ? Буцалж байгаа уснаас уур гарч байгаагаас тэр. Уснаас гарсан тэр уур данханд багтахаа байж тагны нүх сүвээр гадагш гарах гэж дээш нь түлхэж байгаа юм.

Ингээд л данх” амь орж” дуугардаг юм. Гэхдээ усны уур юм чинь дорхноо л замхраад алга болно. Тэр “юу ч биш” гэж бодуузай. Үнэндээ тэр бол асар их хүч тэнхээтэй эд. Хэрвээ хэн нэгэн сониуч этгээд данхны тагийг битүүлж, цоргоны нүхийг бөглөж орхих юм бол усны уур хэмээгч тэр их хүчтэн данхыг ёстой нэг будаа болгож орхино. Иймийн учир эрт дээр цагаас хүн төрөлхтөн усны уурын энэ их хүч чадлыг анзаарч түүнийг нь өөртөө ашигтайгаар хэрэглэж уурын тэргийг зохион бүтээсэн юм шүү.

(“Танин мэдэхүй” сэтгүүлээс)

1. Үгийн утгыг тайлбарлаарай. (2 оноо)

Утгыг тайлбарлах үгс	Үгийн утгыг тайлбарла
данх	
уур	

2. Эхээс учир шалтгааныг тайлбарласан өгүүлбэрийг олж бичээрэй. 2 оноо

.....
.....
.....
.....
.....
.....

3. Дараах үгийг бүтээврээр задалж, бүтээвэр тус бүрийг нэрлээрэй. 2 оноо
Дуугардаг-

.....
.....
.....

4. Хүснэгтэд тохирох жишээ эхээс олж бичээд тайлбарлаарай. (2 оноо)

	Тайлбар
Эхээс тохирох жишээ	
Дүрслэл:	
Баримт:	

5. Зөв бичих дүрмийг тайлбарлаарай. 2оноо
Давт-х-

.....
Янзага- аар-

8-Р АНГИЙН МОНГОЛ ХЭЛ ХИЧЭЭЛИЙН АНГИ ДЭВШИХ ШАЛГАЛТЫН ДААЛГАВАР

“ХУВИЛБАР-Б”

Анги бүлэг
Хугацаа: 60 минут

Сурагчийн нэр
Нийт – 20 оноо

Эхийг уншиж ойлгоод, даалгаврыг гүйцэтгэнэ үү.

Ооно шаргачин хоёр

Ооно шаргачин хоёр гэдгийг Мэнэнгийн их талд л барааг нь харав даа. “Ооно шаргачин хоёр огло тогло харайна” гэсэн эртний үлгэрийг гэнэт санан Мэнэнгийн халиун өвсөн дотроос алтан бэлзэг олох мэт баярлаж билээ. Салхи сөрөн сэртэлзэж, анир аван хулжиж, намрын шаргал талдаа алтан амиа тээнэ. Дэлхийн хязгаарт хүрчих юм шиг дэгдэж дүүлэн ухаа толгод арлаж өвөрлөн хүч тамираа барна. Салхин дундаа жаргаж яваа нь тэр юм болов уу? Жаргал гэхэд ч бас айдас нүүрлэсэн орчлонд сүүдрээсээ ч цочин бусгах нь адтай. Үгүйрч дундардаг орчлонд үр удмаа үлдээх юмсан гэж утсан чинээ улаан голоо салхин сэвшээнээс хүртэл харамлаж яваа нь тэр биз дээ хөөрхийс.....

..... Зээр сүрэглэхэд Мэнэнгийн тал хөдлөх шиг болдог гэсэн үг “Гэсэр”, “Жангар” шиг алслах вий гэхээс дахиад л сэтгэлд уйтгар нөмөрнө.

“Ооно шаргачин хоёр огло тогло харайна”. Айсандаа алтан амиа харамласандаа харайна. Хоёр их хангайн өрийг цөмлөсөн дэлгэр талдаа л харайна. Энэ чухамдаа эртээ урьдын цагт зээр гэдэг будаа шиг буцалж байсан юм гэсэн, хайрхаан !

Мэнэнгийн талд сүүдэр хүүшилнэ. Сүүдэртэй хамт айдас наашилна. Уул нь уулаараа, тал нь талаараа хорвоод ургахын улаан нарыг халуун бүлээрээр угтаарай. Чамд ерөөл тавья. /Санжийн Пүрэв /

1. Үгийн утгыг тайлбарлаарай. /2 оноо/

Утгыг тайлбарлах үгс	Үгийн утгын тайлбар
Ооно	
Бэлзэг	

2. Эхээс өрөвдсөн өнгө аяс бүхий өгүүлбэрийг олж бичнэ үү? \ 2 оноо \

.....
.....
.....

3. Дараах үгийг бүтээврээр задалж, бүтээвэр тус бүрийг нэрлээрэй. \ 2 оноо \
Дундардаг-

.....
.....
.....

4. Хүснэгтэд тохирох жишээ эхээс олж бичээд тайлбарлаарай. (2 оноо)

Эхээс тохирох жишээ	Тайлбар
Дүрслэл:	
Баримт:	

